



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 8










Улаанбаатар хот

Удирдлагуудыг чөлөөлөх, томилох тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Дүрмийн 9.4.7-р заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Борлуулалт үйлчилгээний газрын захирал Т.Молорыг 2023 оны 03-р сарын 16-ны өдрөөр тасалбар болгон үүрэгч ажлаас чөлөөлж, Борлуулалт үйлчилгээний газрын захирлын орон тоонд тохирох этгээдийг томилох хүртэл хугацаанд Борлуулалт үйлчилгээний газрын захирлын ажил үүргийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-р хавсран гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Санхүүгийн газрын захирал С.Дашдоржийг 2023 оны 03-р сарын 16-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
3. Санхүүгийн газрын дэд захирал Д.Бүдхандыг 2023 оны 03-р сарын 16-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлж Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер албан тушаалд томилсугай.
4. Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер нарын цалин урамшууллын багцыг хэвээр үлдээхээр шийдвэрлэсүгэй.
5. Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллертой Хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн болон нууц хадгалах тухай гэрээг байгуулахыг Захиргаа, Хүний нөөцийн газрын захирал (Г.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД			
	О.БАТМӨНХ			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД			
	В.ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
Тогтоолын батлагдсан хувь:		100%		